



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2001 оны 9 дугаар  
сарын 27 ны өдөр

Дугаар 307

Улаанбаатар  
хот

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сэнгээ овогтой Даваадоржийг Австрали улсын Бонд Их сургуулийн магистрантурт олон улсын харилцааны чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Пүрэв овогтой Баасанхүүг АНУ-ын Олон Улсын Харилцааны сургуулийн магистрантурт олон улсын менежментийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД - 2

*С. Эрдэнэ*

А.ЦАНЖИД

*Бүтээгдэхүүн үнэмлэх: с/м Т. Мухомаров*

*2001.9.27*